



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/209

Мандалговь

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн
хааж буй иргэдэд сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам"-ын 4 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 4.2, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 9 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цэргийн штабын "Сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийг зарлан дуудаж "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл", "Тусгай үүргийн бэлтгэл" сургалтыг Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн сургалтын материаллаг баазыг түшиглэн 2020 оны 9 дүгээр сарын 14-наас 9 дүгээр сарын 27-ний өдрийг дуустал 14 хоногийн хугацаатайгаар зохион байгуулсугай.

Хоёр. Сургалтад хамрагдах бүрэлдэхүүний хоолны зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 103 дугаар тогтоолын дагуу хүнсний хангамжийн хоногийн хэмжээг 35 хүнээр тооцож, нэгдүгээр хүнс, хоёрдугаар хавсралтаар сургалтад шаардагдах бусад зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Сургалтыг хөтөлбөрийн дагуу чанартай зохион байгуулж явуулахыг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх), орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер (дэд хурандаа Ц.Баттулга) нарт даалгасугай.

Дөрөв. Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг үндэслэн цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийг аймаг, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, Коронавирус (Covid-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д үүрэг болгосугай.

Тав. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийн сургалтын зардалд шаардагдах 4.442.380 (дөрвөн сая дөрвөн зуун дөчин хоёр мянга гурван зуун наяд) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010585

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



А. Хоолны зардал / Засгийн газрын 103 тоот тогтоолын дагуу цэргийн жинхэнэ албаны байлдагч, түрүүч, сонсогч болон гэрээт цэргийн хоолны нормоор/

№	Хүнсний бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нэг хоногийн норм /гр/	Хугацаа	Хүний тоо	Хэрэгцээ /кг/	Нийт дүн
	Мах	кг	6,500	420	14	35	205.8	1,337,700
Ногоо	Төмс	кг	1,800	500	14	35	245.0	441,000
	Манжин	кг	1,800	20	14	35	9.8	17,640
	Лууван	кг	1,800	40	14	35	19.6	35,280
	Байцаа	кг	2,000	100	14	35	49.0	98,000
	Сонгино	кг	3,000	40	14	35	19.6	58,800
	Гурил	кг	1,900	100	14	35	49.0	93,100
Хуурай хэрэглэл	Цагаан будаа	кг	3,200	60	14	35	29.4	94,080
	Бусад будаа	кг	3,100	40	14	35	19.6	60,760
	Төрөл бүрийн гоймон	кг	4,000	40	14	35	19.6	78,400
	Ургамлын тос	кг	3,600	25	14	35	12.25	44,100
	Элсэн чихэр	кг	2,800	70	14	35	34.3	96,040
	Давс	кг	1,200	25	14	35	12.25	14,700
	Цуу	кг	3,300	5	14	35	2.45	8,085
	Талх	кг	2,000	600	14	35	294.0	588,000
	Томат соус	кг	6,800	10	14	35	4.9	33,320
	Цэвэр ус	ш	400	1	14	35	490.0	196,000
	Ариун цэврийн цаас	ш	750	1	14	35	35.0	26,250
	Нийт дүн							

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр
08.-ны өдрийн 11/2020 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

Б. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдэд сургалт явуулах сургалтын шатахууны зардал

№	Нэр	Марк	ШТМ-ын үнэ	Нийт зарцуулах ШТМ /л/	Нийт явах км	Мөнгөн дүн
1	Тээврийн зардал	Пургон	1540	18	100	
2		Vanguard	1540	18	100	
Бүгд				55.440		

В. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдэд сургалт явуулах сургалтын бусад зардал

№	Нэр	Хүний тоо	Өдрийн хөлс	Бүгд	Тайлбар
1	Сургагч багш	14/ өдөр 1-н багш хичээл заана	30.000	420.000	
2	Тогооч	1	20.000	280.000	
Бүгд				700.000	

Г. Шаардлагатай материал зардал

№	Нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Анисны үрэл	24	450	10.800
2	Ахуйн бээлий	1	2.500	2.500
3	Бинт	3	1.950	5.850
4	Витамин	30	350	10.500
5	Даралтны аппарат бугуйн	1	55.000	55.000
6	Дуовит эрэгтэй	60	830	49.800
7	Жигут ягаан	1	3.500	3.500
8	Ибупрофин	10	130	1.300
9	Идэвжүүлсэн нүүрс	150	50	7.500
10	Мезимфорте	20	300	6.000
11	Полдан миг	5	1.000	5000
12	Хөвөн	3	1.700	5.100
13	Хуруун лент	3	50	150
14	Ципринол	50	800	40.000
Бүгд				203.000

Д. Хийн газ

№	Материалын нэрс	Нэг бүрийн үнэ	Хэрэгцээ	Бүгд
1	Хий	2500	65.074	
Бүгд				162.685

Е. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдэд сургалт явуулах сургалтын бусад зардлын нэгдсэн тооцоо

Сургалтанд хамрагдах	Хугацаа	Зардал /төг/			Нийт дүн
Хүний тоо	хоног	Хоолны зардал	Тээвэр /төг/	Шаардлагатай материал	
35	14	3.321.255	55.440	1.065.685	4.442.380